

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-5</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>6-14</i>

<i>1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлт</i>	<i>6-14</i>
--	--------------------

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 10 дугаар сарын 03-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 10 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Ц.Мөнх-Оргил, Г.Занданшатар, Л.Оюун-Эрдэнэ;

Тасалсан: А.Адъяасүрэн, Х.Нямбаатар.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийг танилцуулав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Н.Энхболд нар үг хэлэв.

Н.Энхболд: 1.Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0

Татгалзсан: 12

Бүгд: 12

0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 12
Бүгд: 12
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 12
Бүгд: 12
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонголт хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 12
Бүгд: 12
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонголт хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 12
Бүгд: 12
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонголт хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 12
Бүгд: 12
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонгог зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 12
Бүгд: 12
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонгог зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 12
Бүгд: 12
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонгог зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 12
Бүгд: 12
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 12
Бүгд: 12
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар ... Ерөнхийлөгч томилно. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 11
Бүгд: 12
8.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

12.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 12
Бүгд: 12
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 36 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 46 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр,
Мягмар гараг

Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим, 14 цаг 10 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдлээ. Энэ учраас 2023 оны 10 сарын 3-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

19 хүнээс 10 хүн ирсэн байна. 52,6 хувиар ирц бүрдсэн байна. Өнөөдөр Байнгын хороогоор 1 асуудал хэлэлцэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлт байгаа. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Цэцийн 05 дугаар дүгнэлтийг та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Авлигын эсрэг хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг Цэц хэлэлцээд хянан шийдвэрлэсэн. Энэ асуудлыг өнөөдөр Байнгын хороогоор хэлэлцэнэ.

Дэгийн тухай хуулийн 82.2.1 Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон холбогдох Байнгын хороо хэлэлцэж бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь

хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргана гэж заасан байгаа.

Хууль зүйн байнгын хороо хэлэлцчихсэн. Холбогдох Байнгын хороо гэдэгт нь Төрийн байгуулалтын байнгын хороо орж байгаа энэ асуудал дээр. Ингээд Үндсэн хуулийн цэцийн 05 дугаар дүгнэлтийг гишүүдэд бүгдээрэнд нь тараасан байгаа.

Асуудлыг Цэц дээр хэлэлцэх үед Улсын Их Хурлаас итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Ганболд гишүүн Цэц дээр ажилласан. Ингээд дүгнэлтийн талаар товч танилцуулгыг Ганболд гишүүн хийнэ ээ. Ганболд гишүүний микрофоныг өгье.

Г.Ганболд: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2 дахь заалт, Авлигын эсрэг тухай хуулийн зарим заалт, Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн зарим заалт, зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг шийдвэрлэх Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Улсын Их Хурлыг төлөөлөн миний бие 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 163 дугаар захирамжаар томилогдсон. Уг хуралдаан тухайн үед 2022 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр зарлагдаж, тухайн мэдээлэл 11 дүгээр сарын 2-нд надад ирсэн.

Үүний дагуу тухайн үед Монгол Улсын 2023 оны төсөв хэлэлцэж байсан Төсвийн ажлын хэсэгт орж ажиллаж байсантай холбогдуулаад тухайн асуудалтай танилцах, тайлбар бичих хугацаа олгох зорилгоор хойшлуулах, өөрийн биеэр оролцох хүсэлт тавьсны дагуу хуралдаан хойшилсон. Үүний дагуу Улсын Их Хурлын хуулийн хэлтэс Хууль

зүйн байнгын хорооны референтүүдтэй хамтран тухайн асуудлаар тайлбараа хүргүүлсэн. Мөн хуралдаанд биечлэн оролцож, тайлбар өгнө гэдгээ бол хэлсэн байгаа. Үүний дараа Үндсэн хуулийн цэцээс дахин хурал зарлахаар товлоод, миний бие байх үед хуралдаан хойшилсон. Сая 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 26-нд дунд суудлын хуралдааныг хийхээр надад албан бичиг ирүүлсэн. Би 26-ны өдөр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын шугамаар олон улсын хуралд оролцохоор билет бичүүлээд явахаар байсан учраас энэ хуралдаанд оролцож чадаагүй ээ.

Ингээд 26-ны өдөр Үндсэн хуулийн цэц дунд суудлын хуралдаанаар хэлэлцээд, шийдвэр гаргасан байгаа. Уг асуудлаар Монгол Улсын иргэн Ж.Батмөнх гэдэг хүн Үндсэн хуулийн цэцэд дараах асуудлаар маргаан үүсгэсэн.

Монгол Улсын төрийн байгуулал нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүх гэсэн төрийн эрх мэдлийн институцэд хуваагддаг. Төрийн эрх мэдэл хуваарилах энэхүү зарчмын зорилго нь төрийн эрх мэдлийг засаглалын салаанд хуваарилж тэдгээр нь бие биедээ харилцан хяналт тавих, тэнцвэрт байдлыг хангахад оршино оо. Нөгөөтээгүүр Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийг хязгаарлаж, халдаж болохгүй.

Гэтэл Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг батлахдаа Ерөнхийлөгчийн бүрэн эрх болон шүүх эрх мэдлийн бие даасан хараат бус байдалд халдсан.

Тодруулбал уг хуулийн 29 дүгээр зүйлийн холбогдох заалтад Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг томилох, Улсын Дээд шүүхийн

шүүгчидтэй танилахдаа нэр дэвшигчийн сонсгол хийхээр заасан байгаа нь төрийн эрх мэдлийн хяналт харилцан тэнцвэрээ алдах, нэг талын бүрэн эрхэд халдаж нөлөөлөхөөр байна.

Нэг.Монгол Улсын үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгчид дотроосоо сонгосон болон нээлттэй нэр дэвшсэн гишүүдийг Монгол Улсын Их Хурал томилохоор заасан. Гэтэл нэр дэвшигчийн сонсгол хийж байгаа нь Монгол Улсын үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, Шүүхийн ерөнхий зөвлөлийн зорилгод үл нийцсэн нөлөөлөхүйц оролдлого юм.

Мөн Шүүхийн сахилгын хорооны шүүгчид дотроосоо сонгосон болон нээлттэй нэр дэвшсэн гишүүдийг томилохдоо нээлттэй сонсгол хийж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүгчийг албан тушаалаар нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын шийтгэл ноогдуулах, Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрхэд халдсан нөлөөлж болохуйц үйлдэл юм.

Иймд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1, 3, 5, 6, 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн байна.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэцийн гишүүний гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын Дээд шүүх санал болгосноор Улсын Их Хурал томилно.

Гэтэл Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Улсын Дээд шүүхийн санал болгож байгаа хүмүүст нэр дэвшигчийн сонсгол хийж байгаа нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч болон Улсын Дээд шүүхийн нэр дэвшүүлэх бүрэн эрхэд шууд халдсан үйлдэл юм. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн гагцхүү Үндсэн хуульд захирагдаж, аливаа байгууллага, албан тушаалтнаас хараат бус байхаар зохицуулсан.

Тиймээс нэр дэвшигчийн сонсгол хийх нэрийдлээр Үндсэн хуулийн цэцийн хараат бус байдалд нөлөөлөх боломж байсаар байна. Угтаа бол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Улсын дээд шүүх нь тодорхой шалгуур үндэслэлээр сонгон санал болгож байгаа тул Монгол Улсын Их Хурал томилох эсэхийг шийдвэрлэх ёстой.

Мөн хуулийн дээрх зохицуулалттай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол хийх гэж оруулсан нэмэлтийг болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. Нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш тухайн тайлан эрх бүхий этгээдийн санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана гэсэн өөрчлөлт оруулсан байгаа нь дээрх байдлаар Үндсэн хуулиар тогтоосон эрх бүхий этгээдийн бүрэн эрхийг зөрчсөн байна.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын Дээд Шүүхийн шүүгчдийг Монгол Улсын Их Хуралд танилцуулах болохоос биш нэр дэвшигчийн сонсгол хийх талаар заагаагүй. Гэтэл Монгол Улсын Их Хурал бас л нэр дэвшигчийн сонсгол хийх нэрийдлээр танилцуулсан хүмүүсийг

буцаах оролдлого хийх боломжтой болоод байна.

Дээрхээс үзвэл Монгол Улсын Их Хурал нь шүүх эрх мэдлийн байгууллага, түүний гишүүдийг санал болгосон байгууллагын бүрэн эрхэд халдаж сонсгол хийх зохицуулалтыг зөвшөөрөл гэсэн агуулгаар харж, өөрөөсөө хараат байлгах, дангаар ноёрхох гэсэн зорилго бүхий хууль баталсан гэж үзэж байна. Ингэснээр шүүх эрх мэдэл нь хууль тогтоох эрх мэдлийн хууль бус ажиллагааг хянах бус хянуулах эрсдэл үүссэн байна.

Үүнээс үзэхэд Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад Үндсэн хуулийн цэцийн гишүүн, 29.1.2 дахь заалтад эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын 9-өөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол гэж заасан нь түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол хийж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна гэж нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш тухайн тайлан санал дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана гэж тус тус хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1, 3, 5, 6, 51 дүгээр зүйлийн 2, 64 дүгээр зүйлийн 2, 3, 65 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчжээ.

Дөрөв. Мөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга гэж зааж үүнтэй уялдуулан

Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт томилгооны сонсгол хийж, мөн зүйлийн 21.2 дахь хэсэгт томилгооны сонсгол хийж гэж хуульчилжээ. Ийнхүү нэр дэвшигчийн сонсгол явуулахаар зохицуулсан нь Авлигатай тэмцэх газрын нэгдмэл удирдлагыг саармагжуулах, бие даасан, хараат бус байх зарчимд нь гаднын хэн нэгэн иргэн болон албан тушаалтны зүгээс нөлөөлөх боломжийг олгох, улмаар үүрэг чиглэл өгөх, амлалт авхуулах зэргээр томилогдсон нөхцөлд цаашид хуулийн дагуу хэвийн үйл ажиллагаагаа ханган ажиллахад сөрөг нөлөө үзүүлэх оролдлого хийх боломжтой байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэснийг зөрчсөн байна.

Иймд дээрх шаардлагад дурдсан зохицуулалтуудыг түдгэлзүүлж өгнө үү гэсэн ийм хүсэлт гаргасан байгаа.

Үүний дагуу Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд Улсын Их Хурлаас баталсан Хяналт шалгалтын хуулийг хамгаалах, энэ хуулийг баталсан үндсэн шалтгаан нөхцөлүүд өмнөх томилгоонууд дээр үүсэж байсан нөхцөл байдлууд өмнөх Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг томилох үеэр бас мэргэжлийн бус тухайн салбартаа ажиллаж байгаагүй хүмүүсийг томилсон нь нийгэмд олон маргааныг давуулсан гэдэг тодорхой үндэслэлүүдийг хуульд заасан үндэслэлүүдийг тайлбарлаж тайлбарыг Үндсэн хуулийн цэцэд хүргүүлсэн болно.

Ингээд 9 сарын 26-ны өдрийн хурлаар Үндсэн хуулийн цэц хэлэлцээд дээрх 7 үндэслэлийн дагуу дүгнэлт гаргасан.

Нэг.Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтад Үндсэн

хуулийн цэцийн гишүүн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол хийж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. Нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш тухайн тайлан санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөлтгүйгээр тусгана гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна. 3 дахь хэсгийн Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал нь Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана. 65 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн Үндсэн хуулийн цэц 9 гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Монгол Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно гэснийг тус тус тус зөрчсөн байна.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад эсвэл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан бусад албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гэсэн хүсэлт гаргасан бол гэж заасны, танилцах, зөвшилцөх гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана. 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын Дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно. 56 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч 6 жилийн

хугацаагаар томилно гэснийг тус тус зөрчсөн байна.

Гурав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1, 3, 5, 6, 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

Дөрөв.Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэгт томилгооны сонсгол хийж гэж тус тус заасан нь түүнчлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

Тав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад Үндсэн хуулийн цэцийн гишүүн 29.1.2 дахь заалтад танилцах, зөвшилцөх гэж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол хийж гэж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна гэж, нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш тухайн тайлан, санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана гэж тус тус заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

Зургаа.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу

дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Баясгалан, гишүүд Солонго, Туулхүү, Эрдэнэбулган, Гангабаатар гэсэн ийм цэцийн дүгнэлт гарсан. Асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Н.Энхболд: Ганболд гишүүнд баярлалаа. Саяын тавьсан танилцуулгатай холбогдуулаад асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй юу. Асуулт тасаллаа шүү.

Ганболд гишүүний танилцуулгатай холбогдуулж үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй юу. Мөнхцэцэг гишүүн. Дараа нь би үг хэлнэ. Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр манай 2020 оны Улсын Их Хурлын эрх зүйн I томоохон шинэчлэл бол энэ парламент, мөн төрийн тодорхой албан тушаалтнуудын томилгоо маань нээлттэй, олон нийтийг хэн гэдэг хүн ямар албан тушаалд томилогдож байгаа тэрийг мэдээлсэн, тэгээд тухайн төрийн өндөр албан тушаалтнуудын эрх зүйн болон бусад ур чадвар, тухайн ажилд томилогдох ёс зүйн болон бусад төлөвшлийг олон нийтийн хэлэлцүүлгээр ингэж гаргаж өгдөг энэ томоохон дэвшлийг хийсэн юм. Энэ бол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн гол үр дүн байсан. Тэгээд бид нар одоо Хүний Эрхийн үндэсний Комисс, Шүүгчийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг нээлттэй сонсголоор томилсон байгаа. Олон нийтийн маань одоо төрөөс хүсэн хүлээдэг I гол зүйл бол шүүхийн шударга ёс. Шүүх хэнийг ч хараат бусаар ажиллаж, хуулийн өмнө ажиллах ёстой. Тэр хэмжээгээрээ хэн нэгэн албан тушаалтан эсвэл тодорхой бүлэглэлийн гэдэг юм уу, эсвэл тодорхой бизнес эрх мэдэл ашиг сонирхолд төлөөлөх ёсгүй.

Тийм учраас Үндсэн хуулийн цэц болон бусад бүх төрийн албан тушаалтнуудад тавигдах шаардлагын 1 нь бол нээлттэй парламент, нээлттэй сонсголын үр дүн байгаа. Энэ дунд суудлын хуралдааны энэ тодорхой албан тушаалтнуудын нээлттэй сонсгол нь Үндсэн хууль зөрчсөн гэдэг энэ дүгнэлтийг бол Улсын Их Хурал хүлээж авах боломжгүй гэж үзэж байна.

Олон түмний чухам хүсэн хүлээдэг төлөөллийн ардчиллын тэгээд зөвлөлдөх парламентын хамгийн гол шинж тэмдэг бол энэ байгаа. Та бид нар бүгд мэднэ. Америкийн Нэгдсэн Улс, Япон гээд дэлхийн гол гол ардчилал өндөр хөгжссөн улс орнуудын томилгоо угаасаа ийм байдаг. Тэгэхээр бид нар ард түмнийхээ мэдэх эрх, нээлттэй мэдээлэл авах эрхийг хүндэтгэж энэ Улсын Их Хурлын хянан шалгах тухай хуулийнхаа заалтуудыг бол хэвээр хадгалах ёстой байгаа. Зүгээр процедурын хувьд зарим нэг бас үл ойлголцол гэдэг юм уу тодорхой үг үсэг дээр бас эргэж харах юмнууд байж болох юм. Тэгэхдээ бид нар ямар ч байсан энэ сонсгол, нээлттэй сонсгол гэдэг бол бол Үндсэн хууль зөрчсөн үйлдэл биш гэдгийг бол анхаарах ёстой.

Тухайлан нарийвчлан үзэхээр цэцийн дүгнэлтэд маань энэ тодорхой 29.1.2 дахь заалт бол Үндсэн хуулийн тэд тэдийг зөрчсөн гэдэг ийм дүгнэлт байгаад байна. Гэтэл сонсгол бол шийдвэр гаргах тийм процесс биш шүү дээ. Сонсголоор олон нийтэд тухайн нэр дэвшиж байгаа хүмүүсийн мэдээллийг хангалттай олгож, ямар хүн бэ гэдгийг л танилцуулах үйл явц байгаа. Энэ бол яг Үндсэн хуулиар олгогдсон Улсын Их Хурлын бүрэн эрхийн хэмжээний үйл ажиллагаа. Тэгэхээр бид нар бол ямар нэгэн хууль зөрчсөн, Үндсэн хууль зөрчсөн ийм заалт бол оруулаагүй ээ. Ер нь бол манай парламент болон Үндсэн хуулийн цэцийн гишүүд бас анхаарах хэрэгтэй. Ер нь төрийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, үндэсний аюулгүй байдал,

бусад нууцтай холбоотой бусад бүх мэдээллүүд аль болох олон түмний хараа хяналт дор явах ёстой. Тэр дотроо өмнөх томилгоонууд хардлага дагуулдаг, маш богино хугацаанд тухайн санал болгосон төрийн эрх бүхий байгууллагын хүмүүсийг Улсын Их Хуралд шууд томилдог энэ процессыг бид нар бол арилгасан. Ард түмнийхээ нүдэн дээр нээлттэй томилуудыг хийх ёстой байгаа. Тийм учраас бид нар Үндсэн хуулийн дунд суудлын хуралдаанаас гаргасан энэ шийдвэрийг хүлээж авахгүй байх нь зүйтэй.

Ер нь бол энэ олон нийтийг мэдээлэлжүүлэх, ардчиллыг хөгжүүлэх томоохон дэвшил гарсан ийм заалтууд байгаа. Тийм учраас манай гишүүд бас энэ дээр анхаарч энэ саналаа өгөх байх гэж бодож байна. Ер нь бол улс төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийнхээ оролцоог хангаж байгаа л хэрэг бол энэ нээлттэй сонсгол гэдгийг бол анхаарах ёстой гэдгийг бол хэлмээр байна.

Н.Энхболд: Баярлалаа. Би нэг товчхон үг хэлчихье. Энэ асуудал өөрөө их том асуудал. Ер нь Үндсэн хуулийн цэц шүүх юм уу, үгүй юм уу гэдгийг онолын талаас нь Үндсэн хууль байгуулагдаад ажиллаж ирсэн хугацааных нь практикт дүгнэлт хийж байгаад бас нэлээн тал талаас нь ярих ёстой асуудал байдаг. Яагаад гэвэл шүүх мөн үү, биш үү гэдэг дээр нь нэгдсэн ойлголттой болчихвол өнөөдрийн Их Хурлаас гаргасан хууль, цэцээс гаргасан дүгнэлт 2 хоорондоо зөрчилдөхгүй байх ийм нөхцөл байдал үүснэ гэж бодож байгаа.

Сонсголын ерөнхий зорилгын талаар бол сая Мөнхцэцэг гишүүн хэлчихлээ. Ерөөсөө л Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол явуулахаар хуульд тусгайлан заасан эс үгүй бол Улсын Их Хуралд танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар гишүүд хүсэлт гаргасан бол үүний дагуу сонсгол

явуулаад, тэр нэр дэвшиж байгаа хүмүүс боловсрол, ажил мэргэжил, туршлага, ур чадвар, ёс зүй хуульд заасан бусад шаардлагад нийцсэн эсэхийг нээлттэй хэлэлцээд олон нийтэд нэр дэвшигчийн талаар мэдэх эрхийг нь хангалтад чиглэсэн ийм процесс байгаа. Бас Мөнхцэцэг гишүүнтэй санал нэг байна. Энэ бол шийдвэр гаргах, эцсийн шийдвэр гаргах процесс үйл ажиллагаа биш. Сонсгол явуулаад ямар ч дүгнэлт гарсан байсан гэсэн Улсын Их Хурал өөрөө эцсийн шийдвэр гарах эрх нь үлдээж байгаа учраас тэр Үндсэн хуульд нийцээж байна гэж үзээд гаргасан хууль гэж бид ойлгож байгаа. Тэгэхдээ Цэц бол өөрийнхөө өнцгөөс хараад ийм дүгнэлт гаргасан юм байна. Тэгээд энийг тойроод сая гишүүд саналаа хэллээ.

Одоо тэгээд хэдүүлээ цэцийн дүгнэлтийн дагуу заалт болгоноор нь санал хураах ажилдаа орно. Гишүүд үг хэлж дууслаа. 12 зарчмын зөрүүтэй санал байгаа. Саналуудтай холбогдуулаад гишүүд асуулт асууж болно. 4 минутаас илүүгүй хугацаагаар. 1 минутаас илүүгүй нэмэлт асуулт тавьж болно. Хангалтгүй гэж үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асуугаад тайлбар авч болно гэсэн ийм заалттай. Энэ дэгийн дагуу санал хураалтаа явуулна.

1 дүгээр санал хураалт. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ санал

дэмжигдсэнгүй. Энэ санал 100 хувиар дэмжигдсэнгүй.

2 дахь санал. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 100 хувийн санал дэмжигдсэнгүй.

3 дахь санал. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 12 гишүүн бүгд дэмжсэнгүй.

4 дэх санал. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонсгол хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 12 гишүүн зөвшөөрсөнгүй.

5 дахь санал. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонсгол хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 100 хувийн саналаар дэмжсэнгүй.

6 дахь санал. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонсгол хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 12 гишүүн санал хураалтад оролцож дэмжсэнгүй.

7 дугаар санал. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор

санал хураалт явуулъя. Санал хураалт. 100 хувийн саналаар дэмжсэнгүй.

8 дугаар санал. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 12 гишүүн оролцож санал нэгтэйгээр дэмжсэнгүй.

9 дүгээр санал. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 12 гишүүн оролцож 100 хувь дэмжсэнгүй.

10 дугаар санал. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал

танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад оролцсон 12 гишүүн дэмжсэнгүй. Бүгд 100 хувийн саналаар.

11 дүгээр санал. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар ... Ерөнхийлөгч томилно. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 12 гишүүн санал хураалтад оролцож 91,7 хувиар дэмжсэнгүй.

12 дугаар санал. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...”

гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 12 гишүүн 100 хувиар саналыг дэмжсэнгүй.

Үүгээр Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Авлигын эсрэг хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хэлэлцэж, хянан шийдвэрлэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос санал, дүгнэлт гаргана. Чуулганы нэгдсэн хуралдаанд Ганболд гишүүн танилцуулна. Мөнхцэцэг гишүүн хууль зүйг унших юм уу. Сарангэрэл гишүүн танилцуулна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дууслаа. Хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

14.46 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ